



МОНГОЛ УЛС  
ДОРНОД АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН 7-Р ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2018 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 09

Чойбалсан

Эрүүл мэндийн салбарын талаар  
авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3, 10.1.4 дэх заалт болон аймгийн Эрүүл мэндийн газрын дарга Ч.Оюунаа, Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн захирал Д.Должин нарын мэдээллийг сонсоод аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

Нэг. Эрүүл мэндийн газар /Ч.Оюунаа/-т ДААЛГАХ нь:

1.1 Батлагдсан төсөв, хүний нөөц, материаллаг баазад нь тулгуурлан 2018 оноос Нийгмийн эрүүл мэндийн төвийг байгуулж, иргэдэд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, чирэгдэлгүй, шуурхай хүргэх,

1.2 Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор сумдын эрүүл мэндийн төвүүдийг мэргэжлийн боловсон хүчнээр хангах, 3000-аас дээш хүн амтай сумдад болон Хэрлэн сумын ерөнхий боловсролын 2-оос доошгүй сургуульд шүд, амны хөндийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх кабинет нээж ажиллуулах,

1.3 Сүүлийн жилүүдэд хүүхэд, өсвөр насныхны дунд осол гэмтэл, амиа хорлолт, хүчирхийлэл, өсвөр насны охидын жирэмслэлт, үр хөндөлт нэмэгдэж, бэлгийн замаар дамжих халдвар ихсэхийн зэрэгцээ архи, тамхи, мансууруулах бодисын хэрэглээ, амьдралын буруу хэв маягаас үүдэлтэй халдварт бус өвчний тархалт нэмэгдэж байгаатай холбогдуулан эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг Боловсрол, соёл, урлагийн газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран зохион байгуулах,

1.4 Эмнэлгийн ачаалал, хүлээгдлийг бууруулах зорилгоор эмнэлэг хооронд өвчтөн илгээх журмыг шинэчлэн боловсруулж, эмнэлгээс эмнэлэгт, эмчээс эмчид гэсэн зарчмыг мөрдлөгө болгох,

1.5 Эмнэлгийн тусламж үйлчилгээний ачааллыг бууруулах зорилгоор төрийн байгууллагад ажиллаж байгаа хувийн эмнэлэгтэй эмч нарын ажлын цаг ашиглалтыг сайжруулах, гэрээ хэлцлийг шинэчлэн байгуулах, гэрээний үүргээ удаа дараа зөрчсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийг, эсвэл үндсэн ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээг цуцлах хүртэл арга хэмжээг авах,



Хоёр. Бүсийн оношлогоо, эмчилгээний төв /Д.Должин/-д ДААЛГАХ нь:

2.1 Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчлүүлэгчдийн хүлээгдэл чирэгдлийг бууруулах, ажлын цаг ашиглалтыг оновчтой болгох, эмч, эмнэлгийн ажилтны ёс зүй, хариуцлага сахилга батыг сайжруулах, тасаг, кабинетуудын өдөр тутмын үзлэг, оношлогоо, шинжилгээ, эмчилгээнд тавих хяналтыг чанаржуулж, үйлчилгээний соёлыг хэвших,

2.2 Улсын Их Хурлын гишүүд, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргын дэмжлэгтэйгээр компьютерт томографи, дижитал рентген, оношлогооны дурангийн аппаратаар хангах ажлыг Засгийн газрын түвшинд тавьж үе шаттай шийдвэрлүүлэх,

2.3 Эмнэлгийн хог хаягдлаас үүдэн гарах эрсдлээс хүн ам, хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгаль орчинд ээлтэй менежментийг дэмжих зорилгоор стандартын шаардлага хангасан хог хаягдлын нэгдсэн байгууламжтай болох,

2.4 Үйлчлүүлэгч, түүний ар гэрээс эм авчруулдаг байдлыг таслан зогсоохын тулд эмийн төсвийг нэмэгдүүлэх талаар санаачилгатай ажиллах, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлж, эмийн бус эмчилгээний аргыг өргөжүүлэх,

Гурав. Аймгийн Засаг дарга /М.Бадамсүрэн/-д ДААЛГАХ нь:


3.1 Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж дэвшилтэт технологийг нэвтрүүлэх үйл ажиллагааг дэмжих зорилгоор өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болох тархины судасны эмгэгийн оношлогооны дуплекс сонографийн /доплер бүхий/ аппарат, бөөр шээсний замын дурангийн мэс заслын багаж хэрэгсэл, нэн шаардлагатай оношлогооны зарим тоног төхөөрөмж авах хөрөнгийн асуудлыг жил бүрийн төсөвт тусгаж шийдвэрлэх,

3.2 Зонхилон тохиолдох сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварын оношлогоо, үзлэг, эмчилгээнд хамрагдвал зохих хүн амыг бүрэн хамруулах талаар төрийн захиргааны байгууллагаас эрүүл мэндийн байгууллагад дэмжлэг үзүүлэх,

3.3 Эрүүл мэндийн салбарт чиглэсэн төсөл, хөтөлбөрийг боловсруулан батлуулж хэрэгжүүлэх,

3.4 Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжүүлэх ажлыг бүх шатны төрийн байгууллага, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн нэгжүүдийн дэмжлэгтэйгээр зохион байгуулж, ажлын явц, үр дүнг жил бүрийн эцэст аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж байх.

ХУРЛЫН ДАРГА



Л.ХИШИГТОГТОХ